



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 02 сарын 08 өдөр

Дугаар 015

Улаанбаатар хот

Дүүргийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил
хамгааллын хэлтсийн хуучин барилгад
үнэлгээ хийлгэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1, 66 дугаар зүйлийн 66.2, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтын 2.1.4, 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дүүргийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын хэлтсийн хуучин барилгыг актлуулахад шаардлагатай үнэлгээг магадлан итгэмжлэгдсэн үнэлгээний компаниар хийлгэхийг зөвшөөрсүгэй.

2. Үнэлгээ хийлгэхэд шаардагдах хөрөнгийн төсвийг хавсралтаар баталсугай.

3. Үнэлгээ хийлгэхэд шаардагдах 2,500,000 (Хоёр сая таван зуун мянга) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын Ерөнхий нягтлан бодогч (С.Баасанхүү)-д зөвшөөрсүгэй.

4. Үнэлгээ хийлгэх ажлыг чанар, үр дүнтэй зохион байгуулахыг Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын хэлтэс (Б.Өлзийбат)-т үүрэг болгосугай.


5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Эдийн засаг, нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан орлогч (Б.Болормаа)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2024 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн 17 дугаар
захирамжийн хавсралт



ҮНЭЛГЭЭ ХИЙЛГЭХЭД ШААРДАГДАХ
ХӨРӨНГИЙН ТӨСӨВ

Д/д	Төрөл	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн зардал	Нийт зардал
1	Үнэлгээний үнэ	ш	1	2,500,000	2,500,000
Дүн					2.500.000